

2019

ТАЙЛАН



Эдийн Засгийн Судалгаа, Эрдэм Шинжилгээний Хүрээлэн



Тайлан 2019

ECONOMIC RESEARCH INSTITUTE



976-11-353470



contact@eri.mn



www.eri.mn

Агуулга


| | |
|---|----|
| Монгол Улсын Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөг боловсруулах төсөлд зориулсан макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн шинжилгээ _____ | 1 |
| Уул уурхай ба тогтвортой хөгжил _____ | 4 |
| Монгол дахь компанийн бондын зах зээлийн хөгжлийн судалгаа _____ | 8 |
| Монгол дахь компанийн бондын зах зээлийн хөгжлийн судалгааны хэлэлцүүлгүүд _____ | 10 |
| Түүхий эдийн зах зээлийн судалгаа _____ | 11 |
| Уул уурхайн бус эдийн засгийн төрөлжилт _____ | 16 |
| Уул уурхайн бирж байгуулах боломжийн судалгаа _____ | 19 |
| Монголын макро эдийн засгийн судалгаа _____ | 21 |
| Төсвийн орлогын удирдлага: Монголын үндэсний баялгийн сангууд ба тэдгээрийн эдийн засагт үзүүлэх нөлөө _____ | 23 |
| 2019 оны хурал _____ | 26 |
| Сумдын орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээ – 2018 _____ | 27 |

Монгол Улсын Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөг боловсруулах төсөлд зориулсан макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн шинжилгээ

Тус судалгааг ЖАЙКА олон улсын байгууллага болон Барилга хот байгуулалтын яамны захиалгаар гүйцэтгэсэн. Судалгааны гол зорилго нь Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөг боловсруулах төсөлд зориулан Монголын макро эдийн засгийн түүхэн хандлага болон хөгжлийн хувилбаруудын урт хугацааны эдийн засгийн таамаглалыг боловсруулахад чиглэсэн. Ингэхдээ судалгааны баг эдийн засгийн хөгжлийн хувилбарууд болон бодлогын нөлөөллийн үнэлгээнд өргөн ашигладаг Динамик Ерөнхий тэнцвэрийн загвар (CGE) боловсруулж ашиглав.

Доорх зурагт харуулснаар, 2000 оноос хойш манай улсын эдийн засаг хурдацтай өсөж, нэрлэсэн ДНБ (ногоон багана) 2000 онд 1.1 тэрбум ам.доллар байсан бол 2018 онд 13.0 тэрбум долларт хүрэв. Энэ хугацаанд, нэг хүнд ногдох ДНБ (шар багана) 474 ам.доллараас 4104 ам.доллар болж өссөн боловч эдийн засгийн өсөлт (ногоон шугам) хүчтэй хэлбэлзэж иржээ. Энэ хэлбэлзлийн гол шалтгаан нь зэс, нүүрсний дэлхийн зах зээлийн үнийн савлагаа, гадаадын шууд хөрөнгө оруулалтын огцом өөрчлөлтүүд байв.

ЗУРАГ 1. ДНБ, НЭГ ХҮНД НОГДОХ ДНБ БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, 2000-2018



Эх сурвалж: Дэлхийн хөгжлийн шалгуур үзүүлэлтүүд, Дэлхийн банк


2000-аад оноос өмнө Монголын эдийн засгийн голлох салбар уламжлалт мал аж ахуй, хөдөө аж ахуйн салбар байсан бол түүнээс хойш Оюу Толгой зэрэг уул уурхайн том төслүүдэд хийгдсэн их хэмжээний гадаадын шууд хөрөнгө оруулалтын нөлөөгөөр уул уурхай, олборлох салбар тэлж, хөдөө аж ахуйн салбарын эдийн засаг дахь хувь нэмэр буурч, манай улсын эдийн засаг уул уурхайн салбараас хамааралтай болсон. 2018 оны

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН

байдлаар уул уурхайн (тэр дундаа зэс, нүүрсний) салбар нийт экспортын 86.7%, нэгдсэн төсвийн нийт орлогын 23.7%, ДНБ-ий 24.3%-ийг тус тус бүрдүүлжээ.

ДНБ-ий өсөлтийн хэлбэлзлийн нэг чухал шалтгаан нь хөрөнгө оруулалтын хэлбэлзэл байсныг Хөрөнгө оруулалт - гарцын харьцаа (ICOR)-аас харж болно. ICOR нь нэмэлт нэгж гарцыг гаргахад шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээг илэрхийлдэг. Дараах зургаас ДНБ-ий өсөлтөд ICOR-ийн хэлбэлзэл буюу хөрөнгө оруулалтын хэлбэлзэл хугацааны хоцрогдолтой нөлөөлж байгааг харж болно.

ЗУРАГ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ - ГАРЦЫН ХАРЬЦАА (ICOR) БА ДНБ-ИЙ ӨСӨЛТ



Эх сурвалж: ҮСХ, Судлаачийн тооцоолол

Сүүлийн жилүүдийн эдийн засгийн өсөлт үр ашигтай байсан эсэхийг тодруулахын тулд бид салбаруудын нийт хүчин зүйлийн бүтээмжийн өсөлтийг Орлуулалтын тогтмол мэдрэмжтэй (CES) функц ашиглан 2010-2018 оны Нийт хүчин зүйлийн бүтээмжийн (TFP) дунджийг тодорхойлсон. Шинжилгээнээс үзэхэд, 2010-2018 онд эдийн засгийн өсөлтийн гол эх сурвалж нь хөдөлмөр болон бүтээмжийн өсөлт биш, харин капиталын нөөцийн өсөлт байжээ.

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН

ХҮСНЭГТ 1. НЭМҮҮ ӨРТГИЙН ӨСӨЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛС БА НИЙТ ХҮЧИН ЗҮЙЛИЙН БҮТЭЭМЖ (TFP), ХУВЬ (2010-2018 ОНЫ ДУНДАЖ)

| | НЭМҮҮ ӨРТӨГ | ХӨДӨЛМӨР | КАПИТАЛ | TFP |
|------------------------------------|-------------|------------|------------|-------------|
| Хөдөө аж ахуй | 9.4 | -0.5 | 10.5 | 9.2 |
| Уул уурхай | 8.3 | 6.8 | 9.3 | 1.4 |
| Аж үйлдвэр | 8.4 | 5.7 | 7.9 | 7.4 |
| Дэд бүтэц | 4.9 | 1.7 | 5.4 | 2.8 |
| Барилга | 12.4 | 5.8 | 19.2 | 3.1 |
| Худалдаа | 7.7 | 4.6 | 13.4 | 2.1 |
| Санхүү, бизнесийн үйлчилгээ | 10.9 | 6.8 | 10.8 | 4.1 |
| Төрийн үйлчилгээ | 1.3 | 2.3 | 0.4 | -0.4 |
| Бусад үйлчилгээ | 2.7 | 1.8 | 2.3 | 0.9 |
| Total | 7.9 | 1.9 | 7.3 | 3.4* |

**салбарын TFP-ийн өсөлтийг ДНБ-дэх жинг ашиглан тооцов.*

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөөг сайн боловсруулахын тулд бодлого боловсруулагчид эдийн засгийн хөгжлийн түүхэн хандлага, хэрэгжүүлсэн бодлогуудын үр нөлөө, хүлээгдэж байгаа эдийн засгийн өөрчлөлтүүдийн дунд ба урт хугацааны таамаглалын талаар тодорхой ойлголттой байх ёстой. Судалгааны баг энэхүү судалгааны хүрээнд Монголын эдийн засгийн 2040 он хүртэлх төсөөллийн гурван боломжит хувилбарыг өөрсдийн боловсруулсан Динамик CGE загвар ашиглан дэвшүүлсэн. CGE загвар нь Валрасын хууль буюу ерөнхий тэнцвэрийн зарчимд тулгуурладаг тул эдийн засагт гарсан аливаа өөрчлөлтийн нийт эдийн засагт үзүүлэх шууд болон шууд бус нөлөөллийг тооцоолж чаддаг. Загварыг боловсруулахдаа суурь өгөгдөл болох 2017 оны Нийгмийн тооцооллын матриц (SAM)-ыг үндэсний тооцооны хүснэгтүүд ашиглан шинээр байгуулсан.

Уул уурхай ба тогтвортой хөгжил

Энэхүү судалгаанд тогтвортой хөгжилд үзүүлэх уул уурхайн салбарын хувь нэмрийг Олон Улсын Байгаль Орчин ба Хөгжлийн Хүрээлэнгийн санал болгосон дараах дөрвөн хүрээнд үнэлэхийг зорьсон. Үүнд:

1. Эдийн засгийн хүрээ (макро эдийн засаг, гадаад худалдаа, төрийн санхүүд үзүүлэх нөлөө)
2. Нийгмийн хүрээ (боловсрол, эрүүл мэнд, технологи гэх мэт)
3. Байгаль орчны хүрээ (уурхай ба түүний нийлүүлэлтийн сүлжээний байгаль орчинд үзүүлэх нөлөө)
4. Засаглалын хүрээ (бодлогын орчин ба компанийн засаглал)

Уул уурхайн салбар Монголын эдийн засагт гадаад, дотоод хүчин зүйлсээр дамжин хүчтэй нөлөө үзүүлдэг. Ардчилсан хувьсгалаас хойших Монголын уул уурхайн салбарын хөгжилд гурван чухал үйл явдал тохиолдсон.

- 2006 онд Ашигт малтмалын хуульд нэмэлт өөрчлөлт орсноор төрийн өмчит уул уурхайн компаниуд байгуулагдаж, уул уурхайн орлогод үндэслэсэн стратеги төлөвлөлт эхэлсэн.
- 2009 онд Оюу толгойн гэрээ байгуулагдсанаар Монголын эдийн засаг хүчтэй тэлж, олон тооны институцийн өөрчлөлт явагдсан. Уг хөрөнгө оруулалтын гэрээ Монгол Улсыг олон улсын санхүүгийн зах зээлд нээж, дотоодын санхүүгийн системийг шинэ шатанд гаргаснаар эдийн засгийн хурдтай өсөлтийг хангах нөхцөлийг бүрдүүлсэн юм. Хүний нөөцийн чанар, сургалт, хөрөнгө оруулалтын системд томоохон ахиц дэвшил авчирсан.
- 2015 онд НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгуудад нийцүүлэн “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030”-ыг баталж, улмаар Үндсэн хуульд урт хугацааны төлөвлөлтийг бэхжүүлэх тухай зааж, эдийн засгийг олон чиглэлд төрөлжүүлэх (тухайлбал, хөдөө аж ахуйг хөгжүүлэх) зорилтыг дэвшүүлсэн. Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ тогтворгүй байдаг тул нөөц бүрдүүлж, эдийн засгийг солонгоруулах шинэ тогтолцоо шаардлагатай байгаа нь улам бүр тодорхой болж байна.

Одоогоор Монголын экспортын дийлэнхийг эрдэс бүтээгдэхүүн эзэлж байгаа бөгөөд эдгээр түүхий эдийн үнээс шалтгаалан улсын төсвийн орлого хэлбэлздэг. Иймээс уул уурхайн бус салбаруудыг хөгжүүлж, экспортыг өргөжүүлэх шаардлагатай байна. Түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэлтэй эрсдэлээс сэргийлж, уул уурхайн орлогыг зохистой удирдахын тулд УИХ Төсвийн тогтвортой байдлын хуулийг баталж, Төсвийн тогтворжуулалтын сан болон Ирээдүйн өв санг байгуулсан. Эдгээр сан хэр ажиллах нь

холбогдох хууль дүрэм хэр бүрдсэн, санг удирдах дүрэм журмыг хэр өргөн хүрээнд хүлээн зөвшөөрч, дагаж мөрдөхөөс хамаарна.

Уул уурхайн орлогыг төв засгийн газар болон орон нутгийн төсөвт хуваарилах нь орон нутгийн хөгжлийг дэмжих чухал хөшүүрэг юм. Монголд уул уурхайн орлогыг орон нутагт хуваарилахдаа зарим татвар, хураамжийг орон нутагт төвлөрүүлэх, Орон нутгийн хөгжлийн сангаар дамжуулах хэлбэрийг ашигладаг. Үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг хуулийн дагуу засгийн газрын холбогдох байгууллагаас авахаас гадна “нийгмийн лиценз” авах нь маш чухал болж байна. Олон нийт, орон нутгийн иргэдийн эсэргүүцлээс шалтгаалан уурхайн ажиллагаа тасалдаж, хойшилсон, бүр хаагдсан хэд хэдэн тохиолдол өнгөрсөн хугацаанд гарсан. Иймэрхүү өртөг зардал ихтэй зөрчлөөс сэргийлэхийн тулд уул уурхайн компаниуд орон нутгийн иргэдээс “үйл ажиллагаа явуулах нийгмийн лиценз” авах шаардлагатай. Олон нийттэй хүнлэг, хүндэтгэлтэй харилцаагаа хадгалах гол арга нь оролцогч талуудтай байнгын харилцаатай байх, мэдээллийг ил тод байлгах, орон нутагтай хөгжлийн гэрээ байгуулах явдал юм.

Уул уурхайн салбарт тулгардаг өөр нэг төвөгтэй асуудал бол хүний эрхийг хангах явдал юм. Уул уурхайн үйл ажиллагаа нь заримдаа хүний амьдарч буй газар, өмч хөрөнгө, чөлөөтэй нүүх эрхийг зөрчдөг. Бичил уурхайн үйл ажиллагаа бас хүний эрхтэй холбогддог. Гэхдээ хувиараа ашигт малтмал олборлогчдын албан бус үйл ажиллагаа орон нутгийн байгаль орчин, нийгэмд бүр илүү сөрөг нөлөө үзүүлэх тохиолдлууд гардаг. Иймээс тэдгээр олборлогч болон тэдний өрхийн амьжиргааг муутгалгүйгээр албан ёсны бүртгэл, хяналтад хамруулах шаардлагатай юм. Ашигт малтмалын тухай хууль болон концессын гэрээнд тодорхой шаардлагууд тавигддаг боловч уул уурхайн компаниуд улс орны хөгжил дэвшилд түүнээс ч илүү тус дэм үзүүлэх шаардлагатай. Тухайлбал, боловсрол, эрүүл мэндийн салбарт уул уурхайн компаниуд хувь нэмэр оруулж болно. Уурхайн үйл ажиллагаа ажиллагсад болон орон нутгийн иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй учраас орон нутгийн удирдлага, эрүүл мэнд хариуцсан байгууллагатай тухайн онцлогт тохируулан хамтран ажиллах шаардлагатай. Мөн ажиллах хүчнээ орон нутгийн иргэдээс бүрдүүлэх шаардлага тавигддаг учраас уул уурхайн компаниуд тухайн улсын боловсролын системд дэмжлэг үзүүлж, орон нутгийн сургуулиудад тусгай мэргэжлийн хичээлийн хөтөлбөр нэвтрүүлэхэд тусалж, мэргэшсэн, чадварлаг иргэдтэй болоход хувь нэмэр оруулах ёстой.

Уул уурхайн салбарын байгаль орчинд үзүүлэх нөлөө нь тогтвортой хөгжлийн хүрээнд хамгийн тулгамдсан асуудал юм. Хэрвээ байгаль орчны асуудлыг хайхралгүй орхивол уул уурхайн салбарын үр өгөөж яваандаа үгүй болно. Монголын хувьд уул уурхайн үйл ажиллагаа хожуу идэвхэжсэн учраас энэ талын хууль эрх зүйн зохицуулалт бүрдэж амжаагүй байна. Одоо үйлчилж буй байгаль орчны зохицуулалтын хэрэгжилт уул уурхайн төслүүдийн үе шатуудад хангалтгүй байна. Хамгийн ноцтой нь уурхайн хаалтыг зөв хийдэггүйгээс шалтгаалан албан бус уурхай эрхлэлт, бэлчээр доройтох,

байгаль орчин бохирдох, иргэдийн эрүүл мэндэд эрсдэл учрах зэрэг байгаль орчин, нийгмийн олон асуудал үүсэж, урт хугацаандаа зардал нэмэгддэг.

Монголын хувьд уул уурхайн салбар дахь сайн засаглалыг дэмжиж, урамшуулах хуулийн орчин тодорхой хэмжээнд бүрдсэн. Гэхдээ ийм бодлого, хууль журам байгаа боловч тэдгээрийг хэрэгжүүлэх, бодит байдалд дагаж мөрдөх нь хамгийн хэцүү асуудал болоод байна. Худалдан авалт, борлуулалтын гэрээ болон уул уурхайн үйл ажиллагаа ерөнхийдөө ил тод бишээс гадна нэг оролцогч тал болох олон нийтийг уул уурхайн үйл ажиллагаанд бүрэн оролцуулдаггүй. Уул уурхайн орлогыг үр ашигтай хуваарилж, тогтвортой хөгжлийг тэтгэхэд тулгарч буй том саад нь авлига юм. Хэдийгээр чухал хуулиудыг баталж, бие даасан агентлаг байгуулах замаар авлигатай тэмцэх хууль эрх зүйн орчныг Монголд бүрдүүлж ирсэн боловч хуулиудын хэрэгжилт хангалтгүй байна. Тэр дундаа уул уурхайн салбар авлигад илүү өртөмхий бөгөөд Монголын уул салбарт авлигын эрсдэл өндөр байгаа нь бусад судалгаагаар тогтоогддог.

Энэхүү судалгааны үр дүнд үндэслээд судалгааны баг дараах санал, зөвлөмжүүдийг дэвшүүлж байна. Үүнд:

- Тогтвортой хөгжилд суурилсан арга хэмжээгээр буюу усны ашиглалт, хууль бус уул уурхай, байгаль орчны бохирдол зэрэг асуудлыг шийдэх замаар уул уурхайг эдийн засгийн бусад салбартай “тэнцвэржүүлэх”.
- Улс орон уул уурхайн нөөцийн талаарх ойлголтоо нэмэгдүүлж, үнийн хэлбэлзэл, өрсөлдөөн, эрдэс бүтээгдэхүүний зах зээлийн өөрчлөлтөд илүү анхаарал хандуулж, эдийн засгийн чухал хэсэг нэгэнт болоод байгаа эрдэс бүтээгдэхүүний үнийг зөв таамаглах чадавхаа бэхжүүлэх.
- Уул уурхайн салбарт зориулсан зөөлөн ба хатуу дэд бүтцийг хөгжүүлэх замаар уул уурхайг бүрэн дүүрэн дэмжих шаардлагатай. Одоогоор дэд бүтэц, боловсролтой ажиллах хүчин дутагдалтай байна.
- ГШХО бол уул уурхайн хөгжлийн чухал хэсэг. ГШХО-ыг цаашид дэмжиж, нэмэгдүүлэх нь уул уурхайн салбарын төдийгүй улс орны тогтвортой өсөлтийг хангах гол нөхцөл болно.
- Монголын эдийн засаг жинхэнэ уул уурхайд суурилсан эдийн засаг болох шилжилтийн эхний шатандаа байгаа учраас солонгоруулах бодлого урт хугацааны чухал зорилго юм. Уул уурхайд тулгуурласан Арабын Нэгдсэн Эмират, Саудын Араб, Норвег, Австрали зэрэг олон орны жишээ уул уурхайн орлогыг эдийн засгийн бусад салбарыг хөгжүүлэхэд зориулж удирдах сайн туршлага нэвтрүүлэхэд тус болно. Үүний тулд бусад салбарын боломжит төслүүд, тэдгээрийн тогтвортой байдлыг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай.
- Манай улсад уул уурхайн салбарын орлогын тогтворгүй байдлыг гэтлэхэд төсвийн, мөнгөний, санхүүгийн илүү сайн тогтолцоог бүрдүүлэх шаардлага

тулгарч байгаа учраас эдийн засгийн тогтвортой байдал өөрөө маш чухал асуудал юм. Иймээс Норвегийн тэтгэврийн сан болон бусад улсын баялгийн сангийн жишээнүүд шавхагдах нөөцийг оновчтой удирдах чухал туршлага, сургамж болно.

Монгол дахь компанийн бондын зах зээлийн хөгжлийн судалгаа

Монгол Улсын санхүүгийн системийн дийлэнх хувийг арилжааны банкнууд эзэлдэг. Банкны салбарын хувьд төвлөрөл ихтэй бөгөөд салбарын нийт активын 68 орчим хувийг хамгийн том гурван банк дангаараа бүрдүүлж байна. Монголд бондын зах зээл, тэр дундаа компанийн бондын зах зээл төдийлөн хөгжөөгүй хэвээр байна. 2001 оноос хойш Монголын Хөрөнгийн Бирж болон Монголын Үнэт Цаасны Бирж дээр нийт 16 компанийн бонд гаргажээ. Эдгээр компанийн нээлттэй бонд ихэнхдээ нэг жилийн хугацаатай байсан.

ХҮСНЭГТ 2. КОМПАНИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТЭРБУМ ТӨГРӨГ

| | 2015 | 2016 | 2017 | 2018 |
|--|------|------|------|-------|
| Банкны бизнесийн зээл | 5548 | 6126 | 6293 | 11773 |
| Банк бус санхүүгийн байгууллагын бизнесийн зээл | 251 | 307 | 394 | 625 |
| IPO болон FPO | 19.6 | 6.3 | 1.3 | 30.4 |
| Нээлттэй бонд | 0.5 | 0 | 0.6 | 1.0 |

Эх сурвалж: ҮСХ, Монголбанк, СЗХ, МХБ, МҮЦБ

Энэхүү судалгааны зорилго нь компанийн бондын зах зээл Монголын санхүүгийн салбарыг цаашид сурталчлах, хөгжүүлэхэд ямар үүрэг гүйцэтгэж болохыг тодорхойлоход чиглэсэн. Судалгааны баг санхүүгийн салбар, макро эдийн засгийн нөхцөл байдал, богино, дунд, урт хугацааны санхүүгийн бодлогын талаар мэдээлэл цуглуулж, өнөөгийн байдал, тулгарч буй бэрхшээлийн дүн шинжилгээнд үндэслэн Монгол Улсад компанийн бондын зах зээлийг хөгжүүлэх арга замыг сайжруулах зөвлөмж дэвшүүлэв.

Судалгааны явцад Монголын компанийн бондын зах зээлийн дийлэнх хувийг хаалттай бонд бүрдүүлдэг болохыг тогтоосон. Гэхдээ хаалттай бондын талаар Үнэт цаасны зах зээлийн тухай хууль (ҮЦЗЗХ) болон Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ны журмуудын ерөнхий заалтуудаас өөр нарийн зохицуулалт байхгүй. Тиймээс хаалттай бондын талаар мэдээллийн нэгдсэн сан, хөрөнгө оруулалтын бүртгэл одоогоор хийгдээгүй байна. ҮЦЗЗХ болон СЗХ-ны журамд зааснаар, хаалттай бонд гаргахдаа сурталчилгаа хийж болохгүй, үнэт цаасны бүртгэлд нээлттэй бондоор бүртгэж, баталгаажуулах журмын дагуу явагдах ёстой бөгөөд хөрөнгө оруулагчдын тоо 50-аас бага байх ёстой (Хуулийн 4.1.21-р заалт).

Холбогдох мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлага, компаниудын өгсөн мэдээлэлд үндэслэн 2018 онд 20 орчим тэрбум төгрөгийн хаалттай бонд гаргасан гэсэн тооцоог хийв. Сүүлийн жилүүдэд хаалттай бонд гаргах нь богино хугацаанд хөрөнгө босгох

нийтлэг арга болжээ. Учир нь хаалттай бонд гаргахад банкнаас зээл авах болон нээлттэй бонд гаргахаас бага хугацаа шаарддаг. Нээлттэй бонд гаргахад олон сарын хугацаа шаарддаг ба энэ хугацаанд компанийн санхүүгийн байдал өөрчлөгдөх эрсдэлтэй. Гэсэн хэдий ч бондын эрсдэлээс шалтгаалан хүү нь жилийн 16-20% орчим байна.

Компанийн нээлттэй болон хаалттай бонд гаргах үйл ажиллагаанд хийсэн судалгааны үр дүнд, дараах бэрхшээл болон мэдээллийн дутмаг байдал ажиглагдсан. Үүнд, институцийн хөрөнгө оруулагчид хангалтгүй, нээлттэй бонд гаргах үйл явц удаан, банкны хадгаламжийн өндөр хүүтэй өрсөлддөг, компанийн бондын, тэр дундаа хаалттай бондын талаарх СЗХ-ны зохицуулалт, журам хангалтгүй зэргийг дурдаж болох юм.

Монгол дахь компанийн бондын зах зээлийн хөгжлийн судалгааны хэлэлцүүлгүүд

СЗХ нь Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА)-тай хамтран Монгол Улсын Хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх төслийг хэрэгжүүлж байна. Төслийн эхний үе шат нь 2014-2017 онд хэрэгжсэн бөгөөд “зах зээлийн найдвартай байдлыг нэмэгдүүлэх замаар IPO-г эрчимжүүлж, давхар бүртгэлийг хэрэгжүүлснээр Монголын хөрөнгийн зах зээлийн орчныг сайжруулах” зорилт тавьж байсан. Төслийн хоёр дахь үе шат нь 2019-2022 онд хэрэгжих бөгөөд Монгол Улсын компанийн бондын зах зээлийг хөгжүүлэхэд илүү анхаарах юм. Түүнчлэн төслийн зүгээс СЗХ, Монголын Хөрөнгийн Бирж (МХБ) болон бусад холбогдох байгууллагуудын хяналт, зохицуулалтын чадавхыг хөгжүүлж, тэдний зах зээлд оролцогчдын талаарх ойлголтыг нь нэмэгдүүлэх замаар зах зээлийн найдвартай байдлаа сайжруулахад нь тусална.

Чадавх бэхжүүлэх үйл ажиллагааны хүрээнд Компанийн бондын зах зээлийн судалгааны хоёр удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулагдсан. Эхний хэлэлцүүлэг 2019 оны 12-р сарын 5-нд СЗХ дээр явагдсан. Энэхүү хаалттай хэлэлцүүлэгт СЗХ-ны холбогдох мэргэжилтнүүд, МХБ, Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв (ҮЦТХТ), Арилжааны Төлбөр Тооцоо ХХК (MSCC) зэрэг байгууллагын удирдлагууд оролцсон.

Хоёр дахь хэлэлцүүлэг 2020 оны 1-р сарын 16-нд Бест Вестерн Примьер Туушин зочид буудлын Соёмбо танхимд болсон. Хэлэлцүүлгийн үеэр гурван танилцуулга хийгдсэн. Эхний танилцуулгад Эдийн Засгийн Судалгаа Эрдэм Шинжилгээний Хүрээлэнгийн захирал, доктор Б. Түвшинтөгс Монголын компанийн бондын зах зээлийн өнөөгийн байдлын талаар танилцуулсан. Хоёр дахь танилцуулгад ноён Норитака Акамацу компанийн бондын зах зээлийг хөгжүүлэхэд тулгарч буй асуудлууд болон тэдгээрийг шийдвэрлэх заавар, зөвлөмжийг танилцуулсан. Сүүлийн танилцуулгад СЗХ-ны Үнэт Цаасны Газраас компанийн бондын зах зээлийн зохицуулалтын орчны талаар танилцуулсан. Эдгээр танилцуулгын дараа СЗХ, Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо (МҮЦАЭХ), МХБ, ҮЦТХТ болон андеррайтингийн компани зэрэг оролцогчдыг хамарсан хэлэлцүүлэг өрнөсөн.


Түүхий эдийн зах зээлийн судалгаа

1. ЗЭСИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА-2019¹

Дэлхийн цэвэршүүлсэн зэсийн эрэлт 2018 онд өмнөх оны мөн үеэс 3 хувиар өссөн бол 2019 оны эхний хагаст тогтвортой байлаа. Эрчим хүчний салбарын эрэлт болон өсөж буй цахилгаан машины үйлдвэрлэлийн улмаас дэлхийн цэвэршүүлсэн зэсийн хэрэглээ ойрын жилүүдэд тогтвортой өсөх хүлээлттэй байна. Цаашид Хятад, Энэтхэг зэрэг орнуудын дэд бүтцийн салбарын хөгжил, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээний өсөлт нь зэсийн эрэлтийг дэмжинэ.

Нийлүүлэлтийн талаас авч үзвэл, 2018 онд цэвэршүүлсэн зэсийн үйлдвэрлэл 2.3 хувиар өссөн бол 2019 оны эхний хагаст 2 хувиар буурлаа. Чили, Индонезийн баяжмалын үйлдвэрлэл буурсан нь боломжит өсөлтийг ихээхэн сааруулжээ. Дэлхийн зэсийн үйлдвэрлэл 2019 онд 0.5 хувиар буурч, 2020 онд 2 хувиар өснө гэж таамаглаж байна. Урт хугацаанд дэлхийн зэсийн үйлдвэрлэл өсөх төлөвтэй байна.

ЗУРАГ 3. ЗЭСИЙН ҮНИЙН ТААМАГЛАЛ, АМ ДОЛЛАР/ТОНН



Эх сурвалж: Дэлхийн банк, ОУВС, BMI Research, Блүүмбэрг

Цэвэршүүлсэн зэсийн үйлдвэрлэл 2018 онд 2 хувиар өссөн бол 2019 оны эхний хагаст 2.7 хувиар буурсан. ICSG-ийн мэдээлснээр дэлхийн цэвэршүүлсэн зэсийн үйлдвэрлэл 2019 онд өмнөх оны түвшинд байх бол 2020 онд 4 хувиар өсөх хүлээлттэй байна. Хятад, Австрали, Бразил, Индонези, Польшийн цэвэршүүлсэн зэсийн үйлдвэрлэл дээрх өсөлтөд голлон нөлөөлнө.

Монголын зах зээлийн хувьд эдийн засгийн хүлээгдэж буй өсөлт дотоодын зэсийн эрэлтийг дэмжинэ. Хятадын засгийн газраас зэсийн хаягдалд тавьсан импортын хориг, цахилгаан машины өсөж буй хэрэглээ зэргийн нөлөөгөөр Хятадын зэсийн импорт богино болон урт хугацаанд тогтвортой өсөх хүлээлттэй байна. Нийлүүлэлтийн талаас

¹ Зэсийн зах зээлийн суурь судалгаа (2017) болон үргэлжлэл судалгаатай www.eri.mn цахим хуудаснаас танилцана уу

цэвэршүүлсэн зэсийн үйлдвэрлэл тогтвортой байна. Харин Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалт хойшилсон, ил уурхайн хүдрийн агуулгын хэмжээ буурсны улмаас богино хугацаанд зэсийн баяжмалын экспорт буурах төлөвтэй байна. Гэхдээ урт хугацаанд Цагаан суварга, Хармагтай зэрэг уурхайн төслүүд хэрэгжиж эхэлснээр зэсийн үйлдвэрлэл өснө.


2. НҮҮРСНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА-2019²

Дэлхийн түүхий гангийн үйлдвэрлэл 2018 онд 4.5 хувиар өсөж, 1808 сая тоннд хүрсэн. Хятадын Засгийн газрын дэд бүтцийн салбарыг дэмжих хөтөлбөрийн нөлөөгөөр гангийн үйлдвэрлэл 2019 онд өсөх хандлагатай байна. Гэхдээ Хятадын байгаль орчны талаарх бодлого дээрх шиг богино хугацааны хөтөлбөрүүдээс илүү ач холбогдолтой байгаа учир энэ өсөлтийн хандлага цаашид удаан үргэлжлэхгүй гэж таамаглаж байна.

Дэлхийн коксжих нүүрсний нийлүүлэлт Австралийн нийлүүлэлтийн өсөлтөөс шалтгаалан богино хугацаанд өсөх хүлээлттэй байна. Австралид шинэ хөрөнгө оруулалтууд болон уурхайн өргөтгөлүүдийн үр дүнд 2019 онд коксжих нүүрсний үйлдвэрлэл 6 сая тонноор нэмэгдэх ажээ. Гэсэн хэдий ч, Австралийн нүүрсний экспорт 2019 оны 2-р сард ихээхэн хэлбэлзсэн. Энэ үед Хятадын боомт, гаалийн агуулахад хуримтлагдсан хэт их нөөцийг багасгахад нэг сарын хугацаа шаардагдсан ба үүний улмаас Австралийн нүүрсний үнэ буурсан.

2019 оны 3-р улирлын байдлаар коксжих нүүрсний үнэ тонн тутамд 177.6 ам.доллар байна. Олон улсын томоохон банкнууд болон судалгааны байгууллагуудын шинжээчид коксжих нүүрсний үнийг 2019 оны 4-р улиралд буурч 158 ам.долларт хүрэх ба цаашид 150 ам.доллар орчимд тогтоно гэж таамаглажээ.

ЗУРАГ 4. КОКСЖИХ НҮҮРСНИЙ ҮНИЙН ТААМАГЛАЛ



Эх сурвалж: Блүүмбэрг, KPMG

²Нүүрсний зах зээлийн суурь судалгаа болон үргэлжлэл судалгаатай www.eri.mn цахим хуудаснаас танилцана уу

2016-2018 онд үнэ нэмэгдэж, эрэлт ихтэй байсан нь эрчим хүчний нүүрсний худалдааг нэмэгдүүлж байсан. Гэхдээ, энэ өсөлт ирэх онуудад буурах төлөвтэй байна. Эрчим хүчний нүүрснээс татгалзаж, усан, цөмийн болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг дэмжих бодлогоос шалтгаалан хөгжингүй орнуудын эрчим хүчний нүүрсний эрэлт буурч байна. Урт хугацаанд БНХАУ эрчим хүчний нүүрсний импортоо бууруулж дотоодын олборлолтоо дэмжих бодлого явуулах төлөвтэй байна. Мөн байгаль орчны бодлогууд эрчим хүчний нүүрсний эрэлтэд сөрөг нөлөө үзүүлж байна.

Монголын коксжих нүүрсний эрэлт Хятадын зах зээлээс хүчтэй хамаардаг. Монгол Улс 2018 онд 31.5 сая тонн, 2019 оны эхний 9 сард 25.1 сая тонн коксжих нүүрс экспортлосон. Хятадын дотоодын уурхайнуудын агуулга бага учир өндөр чанартай коксжих нүүрсний импорт цаашид нэмэгдэх төлөвтэй байна. Иймээс өндөр чанартай коксжих нүүрсний тусламжтайгаар цаашдаа Монголын олборлолт Австралийг ардаа орхиж, Хятадын хамгийн том нийлүүлэгч болох боломж бүрдээд байна.

3. АЛТНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА-2019³


Дэлхийн алтны эрэлт 2019 оны эхний хагаст өмнөх оны мөн үеэс 8 хувиар өссөн. Үүнд гоёл чимэглэлийн алтны эрэлтийн өсөлт, хөрөнгө оруулалтын болон төв банкнуудын худалдан авалтын эрэлт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн. Дэлхийн эдийн засгийн тогтворгүй байдал хөрөнгө оруулалт, төв банкны худалдан авалтын эрэлтийг цаашид нэмэгдүүлнэ.

Уурхайн олборлолт, дахин боловсруулсан алт, олборлолтод тулгуурласан үйлдвэрлэгчийн хэджинг (net producer hedging)-ээр тодорхойлогддог алтны нийлүүлэлт 2019 оны эхний хагаст өмнөх оны мөн үеэс 2 хувиар өссөн. Үүнд томоохон алт үйлдвэрлэгч орнуудын үйлдвэрлэл 4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн. Ойрын хугацаанд үйлдвэрлэлийн өсөлт үргэлжлэх төлөвтэй байгаа тул алтны нийлүүлэлт нэмэгдэх төлөвтэй байна.

Дэлхийн эдийн засгийн тогтворгүй байдлын улмаас 2019 оны туршид нэг унц алтны үнэ 1350 ам.доллар болж буурч болзошгүй байна. Гэхдээ цаашдаа Холбооны Нөөцийн Сан бодлогын хүүгээ бууруулж, хэд хэдэн улсын төв банк мөнгөний зөөлөн бодлого баримтлах болсноор алтны үнэ өсөх хүлээлттэй байна.

³ Алтны зах зээлийн суурь судалгаа болон үргэлжлэл судалгааг www.eri.mn цахим хуудаснаас үзнэ үү

ЗУРАГ 5. АЛТНЫ ҮНИЙН ТААМАГЛАЛ, АМ.ДОЛЛАР/УНЦ



Эх сурвалж: Дэлхийн банк, Fitch Ratings, Блүүмбэрг

Монголбанкны хэрэгжүүлж буй Алт-2 хөтөлбөр, 2018 онд алтны худалдан авалтыг өмнөх оноос 10 хувиар нэмэгдүүлэх зорилт зэрэгтэй холбогдуулан Монголын алтны эрэлтийг өснө гэж таамаглаж байна. Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт төлөвлөгөөний дагуу хэрэгжиж, нэмэгдэж буй хайгуулын өрөмдлөгийн үр дүнд бусад төслийн алтны нөөц өсөж байгаа зэргийг авч үзвэл Монголын алтны нийлүүлэлтийн төлөв цаашид эерэг байна. Хайгуулын болон олборлолтын лицензийн худалдан авах ажиллагаанд хийгдсэн хууль эрх зүйн өөрчлөлтүүд цаашид алтны нөөцийг нэмэгдүүлэх төлөвтэй байна.

Харин 2019 оны 1-р сараас алтны АМНАТ нэмэгдсэнээр олборлолтын зардал өсөж, Монголбанкны худалдан авалтыг бууруулан, цаашдаа Монгол Улсын алтны эрэлтийг бууруулах төлөвтэй байна. Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт хойшлогдсон ч хайгуулын үр дүнд алтны нөөц өсөж, алт боловсруулах үйлдвэр байгуулахаар төлөвлөж байгаа нь ирээдүйд алтны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

4. ТӨМРИЙН ХҮДРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА-2019⁴

Төмрийн хүдэр бол гангийн үйлдвэрлэлийн үндсэн орц юм. Иймээс гангийн үйлдвэрлэл уг түүхий эдийн эрэлтийг тодорхойлдог. Дэд бүтцийн төслүүдэд хөрөнгө оруулалт хийх засгийн газрын шийдвэрийн үр дүнд 2019 оны эхний хагаст Хятадын түүхий гангийн үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 5.3 хувиар өсөж 926 сая тоннд хүрсэн. Гэсэн хэдий ч, Хятадын засгийн газрын дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр дууссаны дараа байгаль орчны талаарх бодлого цаашид үргэлжилснээр гангийн эрэлт буурах төлөвтэй байна.

Нөгөө талаас, дэлхийн төмрийн хүдрийн нийлүүлэлтийг Австрали, Бразил улсууд тодорхойлдог. 2018 онд төмрийн хүдрийн үйлдвэрлэл 2.5 тэрбум тоннд хүрч, өмнөх оны


⁴ Төмрийн хүдрийн зах зээлийн судалгаа 2017, 2018 -тай www.eri.mn цахим хуудаснаас танилцана уу

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН

мөн үеэс 2.8 хувиар өссөн. Австрали, Бразилд төмрийн хүдрийн үйлдвэрлэл өссөн ч Хятадын үйлдвэрлэлийн бууралт боломжит өсөлтийг сааруулжээ. Австралийн төмрийн хүдрийн үйлдвэрлэл 2020 онд 6 хувиар, 2021 онд 2.2 хувиар өсөх хүлээлттэй байна. Бразилын төмрийн хүдрийн үйлдвэрлэл богино хугацаанд тэлж, цаашдаа тогтвортой өсөх төлөвтэй байна.

Төмрийн хүдрийн үнэ 2019 онд тонн тутамд 88.8 ам.долларт хүрч, харин 2022 онд 72.2 ам.доллар болж буурах хүлээлттэй байна. 2019 оны хувьд Австрали, Бразилд үүссэн нийлүүлэлтийн тасалдал, Хятадын өндөр эрэлт зэрэг нь төмрийн хүдрийн үнийг нэмэгдүүлнэ. Гэхдээ цаашдаа Бразил, Австралийн үйлдвэрлэл сэргэж, төлөвлөгдөж буй уурхайнууд ашиглалтад орсноор нийлүүлэлт нэмэгдэн, үнэ буурах хүлээлттэй байна.

ЗУРАГ 6. ТӨМРИЙН ХҮДРИЙН ҮНИЙН ТААМАГЛАЛ, АМ ДОЛЛАР/ ТОНН



Эх сурвалж: Блүүмбэрг, Дэлхийн банк

Монгол Улсын төмрийн хүдэр олборлогчид бүтээгдэхүүнийхээ дийлэнх хэсгийг БНХАУ руу экспортолж байна. 2018 он болон 2019 оны эхний хагаст үнэ өндөр байсантай холбоотойгоор Монголын төмрийн хүдрийн экспорт огцом өссөн. Цаашид, байгаль орчны бодлогын хэрэгжилт, гангийн үйлдвэрлэлийн бууралтын нөлөөгөөр Хятадын төмрийн хүдрийн импорт буурах хүлээлттэй байна. Хэрвээ дотоодод баригдахаар хүлээгдэж буй гангийн үйлдвэрүүдийн төсөл амжилттай хэрэгжвэл цаашид уг түүхий эдийн эрэлтийг нэмэгдүүлэх боломжтой юм.


Уул уурхайн бус эдийн засгийн төрөлжилт

2000 оноос хойш Монголын уул уурхайн салбар хүчтэй тэлж, эдийн засгийн өсөлт эрчимжихийн сацуу эдийн засгийн голлох салбар нь хөдөө аж ахуйгаас уул уурхай болж бүтцийн өөрчлөлт явагдсан. Гэхдээ эдийн засгийн өсөлт тогтворгүй байгаа нь бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчид, бодлого боловсруулагчдад тодорхой бус байдлыг үүсгэж байна. Иймд эдийн засгийг төрөлжүүлж, уул уурхайн салбарын сөрөг шокууд болон ашигт малтмалын үнийн хэлбэлзэлд дархлаатай болгох нь бизнесийн болон хөрөнгө оруулалтын орчны тодорхой бус байдлыг бууруулах чухал ач холбогдолтой юм. Засгийн газраас олон жилийн турш эдийн засгийн төрөлжилтийг бодлогын тэргүүлэх чиглэлээр тодорхойлж ирсэн.

Азийн хөгжлийн банк (АХБ)-ны захиалгаар гүйцэтгэсэн эл судалгаагаар Монголын экспортын төрөлжилтийн өнөөгийн нөхцөл байдал, эдийн засгийн төрөлжилтөд саад болж буй хүчин зүйлсийг тодорхойлсон. Судалгааны гол мэдээллийг Монголын экспортлогч жижиг, дунд үйлдвэр (ЖДҮ) эрхлэгчдээс гүнзгийрүүлсэн ярилцлагын аргаар цуглуулсан. Анхдагч чанарын мэдээлэл болон хоёрдогч тоон мэдээллийн шинжилгээний үр дүнд тулгуурлан уул уурхайн бус эдийн засгийн төрөлжилтийг хэрхэн дэмжих талаар бодлогын зөвлөмж боловсруулсан.

Монголын уул уурхайн бус экспортын нийт экспортод эзлэх хувь 2000 онд 50% байсан бол 2018 онд 11% болж буурсан нь экспортын төрөлжилт улам буурсныг илтгэж байна. Цаашилбал, судалгааны баг PRODY индексийг ашиглан экспортын боловсруулалтын түвшний индексийг тооцсон.

ЗУРАГ 7. ЭКСПОРТЫН БОЛОВСРУУЛАЛТЫН ТҮВШНИЙ ИНДЕКС, 2000-2016



Эх сурвалж: Дэлхийн банк, Дэлхийн хөгжлийн шалгуур үзүүлэлтүүд, Atlas of Economic Complexity-ийн тоон мэдээллийг ашиглан тооцов

Тус индексээр хэмжихэд манай улсын экспортын бүтээгдэхүүнүүд Хятад, Өмнөд Солонгос, Казакстан зэрэг улсынхтай харьцуулахад боловсруулалтын түвшин бага байна. Энэ нь манай улс харьцангуй бага нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнүүд экспортолж байгаа нь эдийн засгийг төрөлжүүлэхэд бүтцийн дорвитой өөрчлөлт хийх шаардлагатай байгааг илтгэж байна. **Error! Reference source not found.**-т харуулсанчлан, 2000-2006 он буюу нийт экспорт дахь зэсийн эзлэх хувь өндөр байсан үед Монголын экспортын боловсруулалтын түвшин харьцангуй тогтвортой байсан. 2006-2012 онд нүүрсний нийт экспортод эзлэх хувь өссөний нөлөөгөөр экспортын боловсруулалтын түвшин өссөн байна. Энэ нь нүүрсний PRODY ангилал зэсээс сайн байдагтай холбоотой юм.

Эдийн засгийн төрөлжилт бага байхад олон хүчин зүйл нөлөөлдгөөс хамгийн гол хоёр хүчин зүйл бол бизнесийн таагүй орчин, институцийн сул хөгжил юм. Эдгээр хүчин зүйл нь хувийн секторын инновац хийх, төрөлжих боломжийг бууруулдаг. Үүнээс гадна, дэд бүтэц, тээвэрлэлтийн сүлжээний сул хөгжил нь хувийн секторын бүтээгдэхүүний төрөлжилтийг улам хязгаарлаж байна.

Экспортлогч компаниудтай хийсэн ярилцлагаас үзвэл, жижиг компаниудын хувьд маркетингийн зардал хэт өндөр байгаа нь экспортын зах зээлд нэвтрэхэд томоохон хүндрэл учруулж байна. Бүтээгдэхүүний шинж чанараас хамааран компаниудад тээвэр, логистикийн бэрхшээл байдаг ба зарим компанийн хувьд захиалгын хүргэлтийн хугацаа, шаардлагыг хангахын тулд маш өндөр өртөгтэй тээвэрлэлт сонгохоос өөр аргагүй болдог аж. Мөн ярилцлагад оролцогчид экспортыг дэмжих засгийн газрын бодлого үгүйлэгдэж байгааг онцолж байлаа.

Бизнес эрхлэгчид засгийн газраас санхүүгийн туслалцаа хүсээгүй ч зээл авах боломж маш хязгаарлагдмал байдаг талаар дурдсан. Харин татвар, гаалийн хөнгөлөлт эдлүүлэх, гаалийн нэвтрүүлэлтийг хялбарчлах зэрэг нь бизнесийн орчныг сайжруулахад хамгийн чухал байгааг онцолсон.

Судалгааны үр дүнгээс харахад, Засгийн газар болон салбарын холбоод нь бүх салбарт тулгамдаад буй зохицуулалтын доголдлыг арилгахад гол үүрэг гүйцэтгэх учиртай. Хөдөө аж ахуйн нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх, өнөөгийн боломжит экспортлогчдод зориулсан мэдээлэл солилцох нэгдсэн платформ, форумууд зохион байгуулах зэрэг арга хэмжээг тогтмол зохион байгуулах нь зохицуулалтын доголдлыг даван туулахад тус болно. Цаашилбал, эдгээр арга хэмжээ нь ЖДҮ-ийг хөгжүүлэх, эдийн засгийн төрөлжилтийг нэмэгдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй. Эцэст нь, улс төр болон бодлогын тогтворгүй байдал Монголын экспортын боломжийг хязгаарлаж буй томоохон хүчин зүйл юм.

Экспортыг нэмэгдүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэхэд зарим орон интервенцийн бодлого хэрэгжүүлдэг ч энэ нь манай улсын хувьд зохистой шийдэл биш юм. Энэ төрлийн бодлогууд, ялангуяа, хувийн секторын оролцоогүй томоохон хэмжээний төрийн хөрөнгө оруулалтын бодлогууд нь төрийн институцийн хөгжил сул орнуудад нөөцийн үр ашиггүй зарцуулалтыг үүсгэдэг.

Иймд, засгийн газар бодлогоо бизнесийн таатай орчин бүрдүүлэх, зохицуулалтын доголдлыг арилгахад илүү чиглүүлэх нь чухал. Бодлогын хэрэгжилтийг сайжруулахад худалдаа, аж үйлдвэрийн танхимууд, салбарын холбоод чухал үүрэгтэй байдаг.

Уул уурхайн бирж байгуулах боломжийн судалгаа

Энэхүү судалгаанд Монгол Улсад уул уурхайн түүхий эдийн бирж байгуулах суурь урьдач нөхцөлүүд хэр бүрдсэн талаар хэлэлцүүлж, хэрвээ уг биржийг байгуулахаар шийдвэл ямар хувилбараар байгуулж болох талаар саналууд дэвшүүлсэн.

Тус хүрээлэнгийн гүйцэтгэсэн “Уул уурхайн салбарын маркетинг ба борлуулалт” (2018) судалгаанд дүгнэснээр, манай улсын экспортын гол түүхий эдүүдийг борлуулахад ихээхэн бэрхшээл учирч байгаагийн нэг гол шалтгаан нь арилжааны платформ, бирж байхгүйтэй холбоотой. Түүхий эдийн онцлог шинж, зах зээлийн хөгжлөөс хамаараад экспортлогчид худалдан авагчаа олох, үнэ тохиролцох, хил нэвтрүүлэх гэх мэт явцдаа олон хүндрэлтэй тулгардаг. Жишээ нь, нэг ордоос нэг ижил ашигт малтмал олборлодог компаниуд шууд борлуулах гэрээндээ ялгаатай үнэ тогтоодог. Энэ нь олборлогчид эцсийн зах зээлийн үнийн талаар бараг мэдээлэлгүй байдаг бөгөөд хоорондоо хамтарч үнээ өсгөхийг боддоггүй, харин дундын зуучлагчид хэт өндөр ашиг хүртдэгийг харуулж байна. Нөгөө талаас, уул уурхайн салбарын борлуулалтын гэрээ ил тод бус учраас татварын алба борлуулалтын бодит үнэд үндэслэж татвар ноогдуулж чаддаггүй.

Иймээс уул уурхайн бирж байгуулж, түүхий эдийг биржээр арилжин, биржийн үнийг ашиглах нь эдгээр асуудлын нэг үр дүнтэй шийдэл байж болох юм. Уул уурхайн бирж нь маркетинг, санхүү, эрсдэлийн менежментийн чухал үүргүүдийг гүйцэтгэдэг. Монголын Экспортлогчдын Холбоо манай улсад уул уурхайн бирж байгуулах боломжтой гэж дүгнэсэн байдаг (2013). Монголын нүүрс, төмрийн хүдэр, зэсийн баяжмалын хэмжээ болон чанар худалдан авагчдын сонирхлыг ихээр татдаг боловч тааруу хөгжсөн тээврийн дэд бүтэц гол бэрхшээл учруулдаг. Манай улс уул уурхайн бирж байгуулъя гэвэл агуулах, логистикийн төв, тээврийн дэд бүтцийг хөгжүүлэхэд ихээхэн хөрөнгө оруулалт хийх шаардлагатай. Мөн өнөөгийн санхүүгийн үйлчилгээний хөгжлийн түвшин болон макро эдийн засгийн орчин хөрш орнуудтай харьцуулахад нэлээд доогуур байгаа нь бас нэг сул тал болдог.

Түүнээс гадна уул уурхайн биржийн талаарх Монголын хууль эрх зүйн орчин ойлгомжгүй, тогтворгүй байна. “Төрөөс эрдэс баялгийн талаар баримтлах бодлого 2014-2025”-д эрдэс баялгийн биржийг хувийн хөрөнгө оруулалтаар байгуулахаар заасан боловч одоогоор төрийн өмчийн Эрдэнэс Монгол компани уул уурхайн бирж байгуулах төсөл хэрэгжүүлж байгаа ажээ. Түүхий эдийн бирж төрийн өмчид байх нь төдийлөн сайн жишиг болохгүйг олон улсад хийгдсэн судалгаанууд сануулдаг. Уул уурхайн биржийг шинээр байгуулах тохиолдолд биржийн арилжааны программ хангамж, сүлжээний тоног төхөөрөмж зэрэг дэд бүтцээс гадна, арилжааг зохицуулах дүрэм журам, засаглал, зохион байгуулалт гэх мэт институцийг бүрдүүлэх, нэлээд олон хууль, тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр батлах шаардлагатай болно. Мөн ур чадвартай боловсон хүчнийг бүрдүүлэх, арилжаанд оролцогч талуудын чадавхыг

бэхжүүлэх ажлууд зайлшгүй шаардлагатай. Эдгээр ажлууд ихээхэн цаг хугацаа, зардал шаардах тул нарийвчилсан техник эдийн засгийн үндэслэл боловсруулж, эрдэс баялгийг биржээр арилжих бусад хувилбартай харьцуулан авч үзэх нь зүйтэй юм.

Эхний нэг боломжит хувилбар бол эдүгээ үйл ажиллагаа нь тогтворжсон Хөдөө аж ахуйн биржийг өргөтгөн, эрдэс баялаг арилжаалах явдал юм. Тус бирж 2013 онд ноолуур, ноос, амьд мал, буудай гэх мэт түүхий эд арилжихаар байгуулагдсан, “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулиар зохицуулагддаг. Тус биржийн ажиллаж ирсэн туршлага нь уул уурхайн бирж байгуулахад чухал сургамж болно. Энэ тохиолдолд эрдэс баялгийн арилжааны программ хангамж, сүлжээний дэд бүтэц тодорхой хэмжээнд бүрдсэн тул зардал багатай, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг бүгдийг цоо шинээр боловсруулах шаардлагагүй зэрэг давуу талтай. Мөн тус биржийн төлөвлөж байгаачлан, нүүрсний арилжааг эхэлж зохион байгуулан, амжилттай болсны дараа бусад эрдэс баялгийн арилжааг нэмэх хэлбэрээр зохион байгуулах нь эрсдэлийг бууруулах боломжтой. Гэхдээ биржийг тусад нь байгуулахтай адилаар, агуулах, тээвэр, логистик, лаборатори, санхүүгийн дэд бүтцийг олон улсын стандарт шаардлагын дагуу бий болгоход ихээхэн хүчин чармайлт, зардал шаардлагатай. Нөгөө талаас, ХАА-н бирж нь 100 хувь төрийн өмчит компани учраас биржийн үйл ажиллагаанд улс төр нөлөөлөх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Өөр нэг боломжит хувилбар нь, эрдэс баялгийн арилжааг гадаадын нэр хүндтэй түүхий эдийн биржтэй хамтран хийх явдал юм. Манай улсын эрдэс бүтээгдэхүүний гол хэрэглэгчийг харгалзан үзвэл хамтран ажиллах боломж хамгийн өндөртэй нь БНХАУ-ын Шанхай, Далиан, Женжоугийн түүхий эдийн биржүүд байна. Өөрөөр хэлбэл, уул уурхайн компаниуд эдгээр бирж дээр, эсвэл биржийн Монгол дахь салбар, төлөөлөгчийн газарт шууд бүтээгдэхүүнээ арилжина. Энэ тохиолдолд биржийг байгуулах, цаашид олон улсад өрсөлдөх чадвартай түвшинд биржийг удирдах зэрэгт цаг хугацаа, зардал ихээхэн хэмнэх, зах зээлийн олон оролцогчдыг татан түүхий эдээ илүү ашигтай нөхцөлөөр арилжих давуу талтай. Гэхдээ нэр хүндтэй биржийн сонирхлыг татаж, хамтын ажиллагааг эхлүүлэхэд хугацаа, хүчин чармайлт их шаардагдана. Мөн түүхий эдээ гадаадын биржийн стандартад нийцүүлэхийн тулд бүтээгдэхүүндээ нэмэлт боловсруулалт хийх шаардлага тавигдаж болно.


Манай улсын хувьд энд дурдсан эдийн засаг, бизнес, хууль эрх зүйн орчны урьдач нөхцөлүүд хангалттай сайн бүрдээгүй байгааг эрдэс баялгийн биржийн үйл ажиллагааг аль ч хувилбараар зохион байгуулахдаа харгалзан үзэх хэрэгтэй. Улмаар эрдэс баялгийн биржийн талаарх бодлогыг Монголын эдийн засаг, бизнесийн орчныг сайжруулах бодлогуудтай уялдуулах шаардлагатай байна.

Монголын макро эдийн засгийн судалгаа


Японы ЖАЙКА байгууллагын захиалгаар гүйцэтгэсэн энэхүү судалгаа нь Монголын макро эдийн засгийн нөхцөл байдлыг тогтмол судалж, гарсан өөрчлөлтийн шалтгаан, цаашдын хандлагыг дүгнэх зорилготой. Судалгааны хүрээнд улирал тутмын тоон мэдээлэл, түүний өөрчлөлт, сүүлийн үеийн хандлагын талаар дэлгэрэнгүй тайлан бэлтгэдэг. Мөн сар тутмын макро эдийн засгийн мэдээний тойм бэлтгэж, захиалагчийг мэргэжлийн түвшинд бэлтгэсэн судалгаа, мэдээллээр тогтмол хангаж ирсэн. Тус судалгаагаар эдийн засгийн өнөөгийн байдал, бодлогын асуудал, эдийн засагт тулгарч буй эрсдэлүүд гэсэн гурван гол хүрээг авч үздэг.

Эдийн засгийн өнөөгийн байдлын талаар судлахдаа эдийн засгийн өсөлт, салбаруудын гүйцэтгэл, арилжааны банкнуудын зээлийн үлдэгдэл, төлбөрийн тэнцлийн улирал бүрийн тоон мэдээллийг цуглуулж, нэгтгэн дүгнэдэг. Түүнчлэн өрхийн сарын дундаж орлого болон зарлага, цалин, валютын нөөц, төгрөгийн ханшийн өөрчлөлтүүд, цаашдын хандлагын талаар дэлгэрэнгүй танилцуулгаар хангаж ирлээ. Мөн дээрх үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг судлахын тулд махны үнийн өсөлт, орлогын тэгш хуваарилалт зэрэг сэдвээр тусгай нэмэлт мэдээлэл бэлтгэсэн. Монголын эдийн засаг хэр идэвхтэй байгааг тодорхойлохын тулд “Эдийн засгийн хэт халалтын индекс”-ийг улирал бүрээр тооцон, дүн шинжилгээ хийдэг. Уг тооцооноос харахад, эдийн засгийн халалт буурснаар эдийн засаг тогтворгүй байдалд хүрэх эрсдэл холдож байгаа боловч эдийн засгийн идэвхжил саарах, экспорт хумигдах, үүнээс үүдэлтэй валютын ханш өсөх, төсвийн орлого тасрах, сонгууль угтаж төсвийн зардал нэмэгдэх эрсдэл ойрхон байна.

ЗУРАГ 8. ЭДИЙН ЗАСГИЙН ХЭТ ХАЛАЛТЫН ИНДЕКС (0 – 100)



ЗУРАГ 9. БОДЛОГЫН ОРОН ЗАЙН ИНДЕКС, (0-100)



Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Бодлогын асуудлын тухайд улсын төсөв, засгийн газрын өр, мөнгөний нийлүүлэлтийн талаар дэлгэрэнгүй авч үздэг. Жишээлбэл Монгол Улсын төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, мөнгөний бодлогын хэрэгжилт, баялгийн сангуудын талаарх мэдээллийг нэмэлтээр оруулсан. Түүнчлэн судалгааны баг эконометрикийн загвар ашиглан эдийн засгийн өсөлтийн богино хугацааны таамаглал дэвшүүлдэг. Мөн эдийн засагт эрсдэл тулгарсан үед макро бодлогын тэлэх орон зай байгаа эсэхийг судалж, дүгнэлт гаргасан. Үүний хүрээнд “Эдийн засгийн бодлогын орон зайн индекс”-ийг улирал тутам тооцоолж байна. Бодлогын орон зайн индекс 100-д дөхөж, их байх тусам тэлэх бодлого явуулах боломж нэмэгдэж байгааг харуулах бол индексийн утга 0-д дөхөж, бага байх тусам тэлэх бодлого хэрэгжүүлэх орон зай хумигдаж байгааг харуулна. Бодлогын нийт орон зайг тус бүр 50 оноо бүхий сангийн ба мөнгөний бодлогын орон зайн нийлбэрээр тодорхойлдог. Зураг 6-д харуулсан уг индексийн тооцоогоор, 2019 оны туршид манай улсын сангийн ба мөнгөний бодлогын орон зайд төдийлөн ахиц гараагүй байна.

Монголын макро эдийн засгийн судалгааны нэг гол зорилго нь цаашид эдийн засагт тулгарч болох эрсдэлүүдийг үнэлэх явдал юм. Энэ хүрээнд түүхий эдийн үнийн хэлбэлзэл, АНУ болон Хятадын худалдааны дайн, банкны салбарын эрсдэл, дотоод улс төрийн тогтворгүй байдал, зудын эрсдэл, COVID-19-ийн халдварын үзүүлэх нөлөө зэрэг томоохон эрсдэлүүдийг судалгаанд дэлгэрэнгүй авч үзсэн.

Төсвийн орлогын удирдлага: Монголын үндэсний баялгийн сангууд ба тэдгээрийн эдийн засагт үзүүлэх нөлөө

Энэхүү судалгааны гол зорилго нь Төсвийн тогтворжуулалтын сан болон Ирээдүйн өв сангийн эдийн засагт үзүүлэх нөлөөг тодорхойлоход оршино. Төсвийн Тогтворжуулалтын Сан (ТТС) нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хүрээнд 2011 онд байгуулагдсан. ТТС-ийн зорилго нь түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдсэн төсвийн зардлын хэлбэлзлээс сэргийлэх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэдэг. Түүнчлэн, Засгийн газар уул уурхайн нөөц баялгийг өнөө үеийнхэн болон ирээдүй үеийнхэнд тэгш хүртээх зорилготой Ирээдүйн өв сан (ИӨС)-г 2016 онд байгуулсан.


Эдгээр баялгийн сангуудын нөлөөг үнэлэхийн тулд бид Динамик CGE загвар боловсруулсан бөгөөд уг загварын тусламжтай эдийн засгийн ирэх 23 жилийн (2019-2040) төсөөллийг дараах 4 хувилбараар боловсруулсан:

- Суурь хувилбар: ТТС ба ИӨС аль аль нь байхгүй;
- Хувилбар 1: ТТС байгаа, ИӨС байхгүй;
- Хувилбар 2: ТТС байхгүй, ИӨС байгаа;
- Хувилбар 3: ТТС ба ИӨС аль аль нь байгаа.

Бид өөрсдийн загвартаа Монгол Улсын 2017 оны Нийгмийн тооцооллын матрицыг Нөөц ба Ашиглалтын Хүснэгтүүд болон бусад тоон өгөгдөл ашиглан байгуулж, ашигласан. CGE загвар нь Валрасын хууль буюу ерөнхий тэнцвэрийн зарчимд тулгуурладаг тул эдийн засгийн нэг талд гарсан өөрчлөлтийн нийт эдийн засаг дахь шууд болон шууд бус нөлөөллийг тооцоолж чаддаг давуу талтай. Баялгийн сангуудын нөлөө уул уурхайн салбарын хэлбэлзлийн үед ямар байхыг харуулахын тулд бид гол ашигт малтмалын үнүүдийн санамсаргүй цуваа үүсгэсэн. Тодруулбал, **Error! Reference source not found.**-д харуулснаар нүүрс болон зэсийн үнэ тэнцвэржүүлсэн үнийнхээ эргэн тойронд хэлбэлзэнэ. Тэнцвэржүүлсэн үнэ нь сүүлийн 12 жил ба ирэх 3 жилийн хүлээгдэж буй үнийн дундаж байна.

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН

ЗУРАГ 10. ЗЭС, НҮҮРСНИЙ ҮНИЙН ТӨСӨӨЛӨЛ




Эх сурвалж: ҮСХ, Судлаачдын тооцоолол


Гол үр дүн:

- ТТС ажиллаж байгаа үед ашигт малтмалын үнийн хэлбэлзэл ТТС-д шингэснээр төсвийн орлогын хэлбэлзэл харьцангуй бага байна. (Зураг 11. Төсвийн тэнцвэржүүлсэн орлого, их наяд төгрөг)
- ТТС нь төсвийн зардлыг тогтворжуулах замаар эдийн засгийн хэлбэлзлийг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэж байна. (Зураг 12. Төсвийн нийт зардал, их наяд төгрөг болон **Error! Reference source not found.**)
- ИӨС нь эдийн засгийн өсөлтийг бууруулах боловч төсвийн зардлын өсөлтийг хязгаарлаж, уул уурхайн орлогыг өнөө болон ирээдүй үеийнхэнд хуваарилахад тусална. (Зураг 12. Төсвийн нийт зардал, их наяд төгрөг болон **Error! Reference source not found.**)

ЗУРАГ 11. ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО, ИХ НАЯД ТӨГРӨГ



ЗУРАГ 12. ТӨСВИЙН НИЙТ ЗАРДАЛ, ИХ НАЯД ТӨГРӨГ



ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН

ХҮСНЭГТ 3. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ХУВЬСАГЧИД

| Макро хувьсагч | ДУНДАЖ ӨСӨЛТ | | | | СТАНДАРТ ХАЗАЙЛТ | | | |
|--------------------------------|--------------|---------|---------|-------------------|------------------|---------|---------|-------------------|
| | Суурь | ТТС-тай | ИӨС-тай | ТТС болон ИӨС-тай | Суурь | ТТС-тай | ИӨС-тай | ТТС болон ИӨС-тай |
| Бодит ДНБ | 4.38 | 4.37 | 4.16 | 4.15 | 0.64 | 0.57 | 0.54 | 0.50 |
| Уул уурхайн бус ДНБ | 4.21 | 4.24 | 4.10 | 4.13 | 3.36 | 2.35 | 3.31 | 2.37 |
| Өрхийн хэрэглээ | 4.22 | 4.23 | 4.07 | 4.07 | 3.76 | 3.64 | 3.80 | 3.70 |
| Засгийн газрын хэрэглээ | 3.87 | 3.83 | 3.93 | 3.90 | 2.92 | 2.32 | 2.88 | 2.33 |
| Нийт хөрөнгө оруулалт | 3.77 | 3.77 | 3.59 | 3.58 | 7.18 | 3.58 | 7.04 | 3.61 |
| Экспорт | 4.41 | 4.41 | 4.34 | 4.35 | 6.87 | 7.20 | 6.99 | 7.29 |
| Импорт | 4.15 | 4.16 | 4.08 | 4.09 | 5.02 | 3.43 | 4.95 | 3.46 |

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

2019 оны хурал

Эдийн Засгийн Судалгаа Эрдэм Шинжилгээний Хүрээлэн (ЭЗСЭШХ) Монгол Банктай хамтран “Эдийн засгийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага” ээлжит хурлаа амжилттай зохион байгууллаа. Энэхүү хурал нь 2019 онд гурав дахь удаагаа зохион байгуулагдсан юм. Тус хурлыг Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА) болон Эдийн Засгийн Бодлогын Түншлэл (PEP) зэрэг олон улсын байгууллагууд дэмжин ажилладаг.

ЭЗСЭШХ-ийн судлаачид бэлчээрийн доройтол ба малын хөлийн татварын нөлөө, Олон Улсын Валютын Сангийн Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөрт учирч болох эрсдэлийн шинжилгээ зэрэг сэдвээр танилцуулга хийсэн. ЖАЙКА-гийн Япон дахь төвийн төлөөлөгч “Байгалийн баялгийн салбар дахь гэрээ” сэдвээр танилцуулга хийсэн. ЭЗСЭШХ-гийн бусад танилцуулга нь ЖАЙКА-тай хамтран хэрэгжүүлж буй “Монголын байгалийн баялаг, уул уурхайн салбарын бодлогын судалгааны чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд тавигдсан. Уг төслийн хүрээнд 2019 оны хуралд “Төсвийн орлогын удирдлага: Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон түүнд заасан шаардлагууд”, “Уул уурхайн салбарын гэрээ”, “Гадаадын шууд хөрөнгө оруулалтын харьцуулсан судалгаа”, “Уул уурхайн салбарын татвар болон санхүүгийн тайлагнал” зэрэг судалгааны үр дүнг хэлэлцүүлсэн. Мөн Монголбанкны судлаачид “Монголын эдийн засгийн өсөлт болон инфляцын дүн шинжилгээ”, “Азийн эдийн засгийн холбоос” зэрэг судалгааны үр дүнг танилцуулсан бол Гэрэгэ Партнерс компанийн судлаачид “Хагас бүтцийн загварын хэрэглээ, богино, дунд хугацааны төсөөлөл хийх” судалгааг танилцуулсан. Энэ бүх танилцуулга Англи, Монгол хэлээр ЭЗСЭШХ-гийн цахим хуудас www.eri.mn-д нийтлэгдсэн.

Сумдын орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээ – 2018

Дэлхийн банкны “Тогтвортой амьжиргаа - 3” төслийн захиалгаар Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)-ийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээг гүйцэтгэв. Үнэлгээнд Баян-Өлгий, Завхан, Увс, Ховд, Хөвсгөл, Орхон зэрэг 6 аймгийн 98 сумыг хамруулсан. Ингэснээр тус хүрээлэн сүүлийн 4 жил дараалан, Монголын бүх 21 аймаг, 330 сумыг хамруулсан үнэлгээг гүйцэтгэлээ. Уг судалгаагаар сумдын ОНХС-ийн 2018-2019 оны үйл ажиллагаа иргэдийн оролцоо, ил тод байдлыг хэрхэн хангасан, төсвийг хэрхэн төлөвлөсөн, сангийн төсвийн гүйцэтгэлд хэрхэн хяналт тавьсныг тусгай шалгуураар үнэлдэг.



Хаяг: Эдийн Засгийн Судалгаа, Эрдэм Шинжилгээний Хүрээлэн (ERI), Бодь Цамхаг, 901 тоот, Жигжиджавын гудамж 3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар, Монгол Улс, 15160

Утас: 976-11-353470

Цахим хуудас: www.eri.mn

Э-Мэйл: contact@eri.mn